

**Монгол заргын бичиг**  
*Судалгааны арга зүй, аргачлалын асуудал*

**Ч. Тамир** (МУИС)  
**Р. Төрдалай** (МУИС)

Энэхүү өгүүлээр бид XVIII-XX зууны эхэн үед холбогдох монголчуудын заргын бичгийг судалсан дүнгийнхээ тухай та бүхэнд урьдчилсан байдлаар танилцуулж, заргын бичгийг судлах болсон зорилго, судлахын ач холбогдол, судлагдсан байдал, цаашдын судалгаанд анхаарах тулгамдсан зарим асуудлын тухайд өөрсдийн саналаа нэмэрлэхийг зорьсон болно.

**1. Зарга, заргын бичгийн тухай ойлголт**

Зарга гэж юу вэ? Уг ойлголтыг тодорхойлохоос судалгаагаа эхлэх нь зохистой юм. Үүнийг олон улсад түгээмэл хэрэглэгддэг *Хүний эрхийн толь бичиг*-т "Эрх бүхий байгууллагын албан тушаалтанд хандан хүний эрхийн зөрчлийг арилгах, тогтоох үүднээс болон зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг хүссэн албан ёсны өргөдлийг хэлнэ"<sup>1</sup> гэж тодорхойлжээ. Харин *Монгол хэлний товч тайлбар толь*-д "Зарга - харилцан заалдаж тэмцсэн тэмцэл"<sup>2</sup> гэж тайлсан байна.

Эндээс үзэхүл, тухайн үед монголчуудын дунд түгээмэл байсан зарга тэмцэл бол эрх ашиг нь хөндөгдсөн асуудлаар харилцан заалдаж буй талууд эрх бүхий байгууллагад зөрчигдөж байгаа эрхээ сэргээх, хангуулахын тулд амаар болон бичгээр хандаж буй нэг буюу бүлэг хүмүүсийн өргөдөл, гомдол гэж ойлгож болно.

Хүний эрх ямар үед, ямар хэлбэрээр зөрчигддөг вэ? Зарга яагаад үүсдэг байсан вэ? Заргын үйл явц хэрхэн төгсдөг байсан вэ? зэрэг олон асуултыг эндээс ургуулан гаргаж болно. Өмнө хийсэн тандалтын шинжтэй судалгаан дээр үндэслэн бид нэлээд хэдэн таамаглалыг болзлом байдлаар дэвшүүлсэн. Судалгаанаас үзэхүл зарга үүсэхэд нөлөөлөх хүчин зүйл, шалтгаан олон янз, өөр хоорондоо ихээхэн ялгаатай байна. Цаашилбал эл хүчин зүйлүүд нь цаг хугацаа, газар нутаг, зарга хийсэн бүлэг зэргээсээ хамааран харилцан өөр өөр байгааг олж тогтоогоод байна. Дашрамд тэмдэглэхэд, монголчуудын зарга тэмцэл амаар заалдах, бичгээр заалдах гэсэн хоёр үндсэн хэлбэртэй байсан бөгөөд бид бичгээр заалдсан заргын тухай тусгайлан авч үзэж байна.

**2. Заргын бичиг нь судалгааны олон талт сурвалж болох нь.**

Заргын бичиг бол Манжийн үеийн Монголчуудын нийгэм, түүхийн судалгаанд үлэмж ач холбогдолтой түүхэн сурвалж юм. Зарга хийх үйл явц нь тухайн үеийн монголчуудын нийгмийн

<sup>1</sup> Виктор Кондэ, Х., *Хүний эрхийн олон улсын нэр томъёоны гарын авлага*, Небраскагийн Их Сургуулийн Хэвлэлийн Газар, 2002.

<sup>2</sup> Я. Цэвэл., *Монгол хэлний товч тайлбар толь*, редактор Х. Лувсанбалдан, Улаанбаатар, Д. Сүхбаатарын Нэрэмжит Хэвлэлийн Комбинат, 1966, 268-р тал

оролцооны түгээмэл хэлбэр болохын хувьд бусад хэлбэрээс<sup>3</sup> ялгагдах ихээхэн онцлогтой, нарийвчлан судлах шаардлагатай асуудал болно.

Үүний тулд бид Зарлигаар зарсан Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайд (Хүрээний сайд)-ын яам, Халхын Дөрвөн аймгийн Чуулганы дарга, жанжны жасаа, дээрхи аймгуудын харъяа хошуу тамгын газруудад өргөн мэдүүлсэн, ирсэн явуулсан бичгүүд, түүний хуулга данс, бусад нугалбар бичиг зэрэг XVIII-XX зууны эхэн үед холбогдох түүхэн сурвалжуудыг шинжилж заргын бичгийг монголчууд хэдий үеэс бичих болсон, зарга үүсэхэд нөлөөлсөн байгаль, нийгмийн хүчин зүйлс, заргын бичигт монголын нийгмийн давхраажилт, тэдгээрийн зөрчлийн үндсэн хэлбэрүүд хэрхэн туссан хийгээд заргын бичлэгийн хэлбэр, онцлог, түүхэн хувьсал өөрчлөлтийг тодруулахад гол анхаарлаа хандуулав.

Ингэснээр Үндэсний Төв Архивт хадгалагдаж байгаа гол төлөв Манжийн үед холбогдох заргын бичгийг шинжлэх тусгайлсан хэрэглэгдэхүүнийг боловсруулан, түүнд агуулагдаж буй мэдээг нэг арга зүйгээр сурвалжлан тодруулахыг оролдсон билээ. Чухамдаа ингэж ардын заргыг судлан үзэхдээ баримт бичиг судлах аргын нэгэн төрөл болох контент анализын аргыг ашиглан, мэдээллийг цуглуулж боловсруулан дүгнэсэн болно. Энэ арга нь мэдээллийн утга агуулгад дүн шинжилгээ хийх арга юм<sup>4</sup>.

Бид судалгаандаа тулгуурлан заргын бичгийн судалгааны ач холбогдлыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

*Нэгдүгээрт*, заргын бичиг нь монголчуудын аж ахуй, соёл, шашин шүтлэг, зан заншлын хүрээнд тэдний амьдралд өдөр тутам тулгарч байсан бэрхшээлтэй асуудлыг тусгаснаас гадна хүсэл мөрөөдөл, амьдралын зорилго, эрхэмлэл, үнэт зүйлс, оршихуй хийгээд нийгэмдээ тэдний хэрхэн хандаж байсан зэргийг давуутай илтгэх\* тул уг асуудлыг нийгмийн харилцаанд нь нэхэн судлах боломжийг буй болгодог. Өөрөөр хэлбэл тухайн үеийн жирийн иргэд хүрээлэн байгаа бодит (байгаль, нийгмийг) ертөнцөө хэрхэн тусган хүлээн авч байгааг ямар нэгэн шүүлтүүргүй харуулах баримт, тэдний социал ертөнцийг тусгах толь мөн. Энэ социал ертөнц нь тухайн үеийн монголчуудын амьдарч байсан байгаль экологийн нөхцөл, нүүдлийн амьдрах хэв маяг, нийгмийн байгуулал, социал харилцааны хэлбэршил зэргээс бүрэлддэг нарийн нийлмэл зүйл юм.

*Хоёрдугаарт*, заргын бичгээс тухайн үед Манж Чин улсаас Монголын талаар баримталж байсан төрийн институтын бодлого, шийдвэр, хууль цааз, алба татвар, орон нутгийн засаг захиргааны бүтэц нь жирийн иргэдийн амьдралд хэрхэн үйлчилж байсан зэргийг тодруулан шинжилж болно. Ялангуяа түшмэл ёс (bureaucracy), төрийн түшмэд захиргааны эрх мэдлийг урвуулан ашиглах явдал (administrative abuse) буюу хууль бус үйл ажиллагаа (авилгал, хээл хахууль, эрх мэдлээ зүй зохисгүй хэрэглэсэн, тогтоосон дэг журмыг зөрчсөн, эс үйлдэл буюу зохих үйлдлийг хийгээгүйгээс иргэдийн хууль ёсны эрх хэрэгжихгүйд хүрсэн зэрэг), татвараас зайлсхийх хэлбэр зэрэг далд эдийн засгийн харилцаа, мөн төрийн байгууллагуудын институтчиллын төвшин, үйл ажиллагааны зохион байгуулалт, хэлбэршил, албан ёсны хууль дүрмээс гадна мөрдөгддөг албан бус хэм хэмжээ, бүтэц зэргийг яруу тод харуулна.

*Гуравдугаарт*, зарга бичиг нь жирийн иргэдийн оюун санааны тал буюу ертөнцийг үзэхүй, нарийвчилбал нийгэм, улс төрийн сэтгэлгээ, үзэл баримтлал, төр иргэний хоорондох харилцаа, иргэдийн зүгээс төрийн талаархи тусгал, төрд хандах хандлага, төв болон орон нутгийн удирдлагын үйл ажиллагааны талаархи санал сэтгэгдэл, шүүмжлэл зэргийг улируулан судлах хэрэглэгдэхүүн болно. Мөн заргын бичиг нь улс төрийн оролцооны түүхэн хэлбэр, Манжийн үеийн монголчуудын нийгмийн бүлгийн үзэл баримтлал, эрх ашгийн ялгаатай ба ижил төсөөтэй талыг тодорхой илэрхийлж буй түүхэн эх сурвалж юм. Түүнчлэн заргын бичгээс тухайн үеийн нийгмийн зөрчлийн үндсэн хэлбэрийг илрүүлэх, нийгмийн дэвшлийн (modernism) тухай

<sup>3</sup> Ш. Содном., "Улс төрийн бүлэглэлүүд ба намууд", Монгол улсын түүх, эрхэлсэн Ж. Болдбаатар, Улаанбаатар, 1999, 121-р тал.

<sup>4</sup> В. Отгоннасан., Ц. Хатантөмөр., "Баримт бичиг судлах арга", Социологийн судалгааны үндсэн аргууд, хянан тохиолдуулсан В. Отгоннасан, Улаанбаатар, 1993, 83-89-р тал.

\* Нэг талаас заргын бичгийн агуулга нь тухайн үеийн Монголын нийгмийн доод давхаргын түүхийг илүүтэйгээр тусгасан мэт байдаг ч чухамдаа бүх давхаргыг хамарч байсан бололтой.

үзэл баримтлал зэрэг олон асуултад хариулт өгөх боломжтой байдаг ба эцэстээ заргын тэмцлийн үйл явц, үр дүн нь дугуйлан, хөдөлгөөн, бослого, зэвсэгт тэмцэл зэрэг Монголын нийгмийг хамарсан хувьсал өөрчлөлттэй хэрхэн уялдаж байгааг тухайн үеийн нийгмийн харилцаанд шүтэлцүүлэн судлах боломжийг олгоно.

*Дөрөвдүгээрт*, заргын бичиг нь социал харилцааны илэрхийлэл болсон нийгмийн страт, бүлгүүдийн харилцан хамаарал, бүтэц давхраажил, гэр бүлийн хэв маяг, ард иргэдийн эрхэлж байсан хөдөлмөр, жөндөрийн харьцаа, нийгмийн халамж, хамгааллын бодлого, хүний эрх зэрэг асуудлыг ч шууд болон дам байдлаар хөнддөг.

*Тавдугаарт*, дээр дурдсанаас гадна заргын бичгээс өгүүлэн буй үеийн монголчуудын албан бичиг хөтлөлтийн уламжлал, дэг жаяг, албан бичгийн соёл зэргийг ч тусгайлан судлах бүрэн боломжтой юм.

### 3. Заргын бичгийг судалсан байдал

XX зууны 50-иад оноос манай судлаачид монголчуудын заргын тэмцлийн түүхийг олон талаас нь (түүх, намтар судлал гэх мэт) дагнасан болон хавсарга шинжтэйгээр судалж эхэлжээ.

Үүнд Ц. Цэдэнжав<sup>5</sup>, Ш. Нацагдорж<sup>6</sup>, Ц.Насанбалжир<sup>7</sup>, Цэ. Шархүү<sup>8</sup>, Г. Цэрэндорж<sup>9</sup>, Ж. Доржсүрэнхорлоо<sup>10</sup> нарыг дурьдаж болно. 1966 онд Академич Ш. Нацагдорж, Ц. Насанбалжир нар Манжийн үеэс Богд хаант Монгол улсын үед холбогдох Халхын Дөрвөн аймгийн 42 заргын бичгийг түүвэрлэн авч тайлбар зүүлт, нэрийн хэлхээний хамтаар эмхтгэн гаргасан нь монголчуудын заргын тэмцлийн түүхийг судлахад чухал хэрэглэгдэхүүн болсоор байна<sup>11</sup>.

Үүнээс гадна Өвөр Монголд энэ чиглэлийн судалгаа чамгүй хийгдсэн бөгөөд Ордосын ард түмний дугуйлангийн хөдөлгөөний түүхэнд холбогдох сурвалж бичгийн эмхтгэлийг 1985-1986 онд 18 дэвтрээр эрхлэн гаргажээ<sup>12</sup>. Мөн судлаач С. Нарсан<sup>13</sup>, Алтан-Оргил<sup>14</sup> нар Өвөр Монголын ард түмний заргын тэмцлийн холбогдолтой эх сурвалжыг эмхтгэн гаргасныг дурдах учиртай.

Түүнчлэн ХБНГУ-д ажиллаж байсан өвөрлөгч эрдэмтэн Рашдондог Германы монгол судлаач В. Файтын хамтаар Ш. Нацагдорж, Ц. Насанбалжирын *Ардын заргын бичиг (XVIII-XX зууны эхэн)* эмхтгэлийг 1975 онд англи хэлнээ орчуулан хэвлүүлсэн билээ<sup>15</sup>. Энэ нь заргын бичгийн ач холбогдлыг харуулах бас нэгэн баримт мөн.

<sup>5</sup> Ц. Цэдэнжав., *Ард Аюуш Мань гүнийг хэрхэн ялав*, Улаанбаатар, 1942.

<sup>6</sup> Ш. Нацагдорж., *"Дарлалыг эсэргүүцсэн зоригт тэмцэгч"* (Ард Аюушийн төрсний 100 жилийн ойд), Үнэн, Улаанбаатар 269(1959).

Ш. Нацагдорж., *Халх дахь үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн ба феодалыг эсэргүүцсэн хөдөлгөөн*, Улаанбаатар, 1941.

Ш. Нацагдорж., *Ховд хязгаарт Ард Аюушийн удирдлаган дор гарсан эрх чөлөөний хөдөлгөөн*, Москва, 1954.

Ш. Нацагдорж., *Ар Монголд гарсан ардын хөдөлгөөн* (Түүхэн найруулал), хянан тохиолдуулсан Х. Пэрлээ, Улаанбаатар, Улсын Хэвлэлийн Газар, 1956, 113 тал.

<sup>7</sup> Ц.Насанбалжир., *Ар Монголоос Манж Чин улсад залгуулж байсан алба, 1691-1911*, хянан тохиолдуулсан Х. Пэрлээ, БНМАУ, Шинжлэх Ухааны Академи, Улаанбаатар, 1964, 186 тал.

<sup>8</sup> Цэ. Шархүү., *Хувьсгалын өмнөх Монгол дахь газрын харилцаа* (Архивын материалын эмхтгэл), хянан тохиолдуулсан Ш. Нацагдорж, Улаанбаатар, Улсын Хэвлэлийн Газар, 1975, 252 тал.

<sup>9</sup> Г. Цэрэндорж., *Засагт хан аймгийн Дархан гүний хошуунд гарсан ардын хөдөлгөөний толгойлогч Ард Аюуш (1859-1939)*, Улаанбаатар, 1959, 38 тал.

<sup>10</sup> Ж. Доржсүрэнхорлоо., *Халхын Сэцэн хан аймгийн ван Тогтохтөрийн хошуунд болсон ард түмний тэмцэл (1839-1844)*, Улаанбаатар, Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн Хэвлэл, 1957, 15 тал.

<sup>11</sup> *Ардын заргын бичиг (XVIII-XX зууны эхэн)*, эмхэтгэсэн Ш. Нацагдорж, Ц. Насанбалжир, хянан тохиолдуулсан Д. Гонгор, Улаанбаатар, Шинжлэх Ухааны Академийн Хэвлэх Үйлдвэр, 1966, 244 тал.

<sup>12</sup> *Ordus arad tümen-ü duuyulang-un ködelgegen-ü material-un emkidkel*, 18 debter, Yeke juu ayimay-un dangsa ebkemel-ün sang emkidken nayirayulba, 1985-1986.

<sup>13</sup> Narasun, S., *Ordus arad-un duuyulang-un ködelgegen*, Kökeqota, Öbür Mongyol-un Arad-un Keblel-ün Qoriy-a, 1989, 530 tal-a.

<sup>14</sup> *Kökeqota-yin teiken mongyol surbulji bičig*, Tabuduyar emkidkel- jaryu jayalduyan-u kereg, Altanorgil yoollan nayirayulba, Qayilar, Öbür Mongyol-un Soyul-un Keblel-ün Qoriy-a, 1989, 292 tal-a.

<sup>15</sup> Rasidondug, S., (mit V. Veit) *Petitions of Grievances Submitted by the People (18<sup>th</sup> -Beginning of 20<sup>th</sup> Century)*, Translated from the Mongol by S. Rasidondug, Collaboration with V.Veit, in *Asiatische Forschungen* 45, Wiesbaden 1975, 209 S.

#### 4. Заргын бичгийн судалгаанд анхаарах аргачлалын зарим асуудал

Хэдийгээр заргын бичгийн тухайд холбогдох олон эмхтгэл материал гарсан боловч уг асуудлыг арга зүйн шинэ хандлагаар сэргээн судлах шаардлага зүй ёсоор үүсч байна. Өөрөөр хэлбэл монголчуудын заргын бичгийн судалгаанд дараах шийдвэрлэх хэдэн тулгамдсан асуудал байгааг дор дурдъя.

Бид өмнө түүхийн социологийн<sup>16</sup> судалгаанд өргөнөөр хэрэглэгддэг контент анализын аргаар манжийн ноёрхлын үе буюу 1750-1911 оны зарим нэг заргын бичгүүдэд<sup>17</sup> шинжилгээ хийж зарим нэгэн дүгнэлтийг болзол байдлаар гарган олны хүртээл болгосон билээ<sup>18</sup>. Бид эл ажил дээрээ тулгуурлан судалгааны ажлаа гүнзгийрсэн төвшинд үргэлжлүүлэн явуулж байна. Гэвч өмнөх судалгаанаас үндэслэн харахад арга зүй, болон аргачлалын хувьд дараах зүйлүүдийг эрхгүй анхаарах шаардлагатай байна. Иймээс заргын бичгийг судлахад анхаарах дараах хэдэн саналыг толилуулъя.

*Нэгдүгээрт*, бидний эхний судалгаа манай нэртэй түүхч Ш.Нацагдорж, Ц. Насанбалжир нарын 1966 онд түүвэрлэн хэвлүүлсэн *Ардын заргын бичиг* эмхтгэлээр хязгаарлагдсан ба гэтэл энэ эмхтгэл нь архивт хадгалагдаж байгаа нийт заргыг түүврийн хувьд төлөөлж чадах уу үгүй юу гэдэг асуулт гарна. Бид дээрх судлаачдын судалгаан дээр дөрөөлөн мордсон бөгөөд улмаар ихэнх судалгаагаа эх сурвалжаас буюу Улсын Төв Архивт үргэлжлүүлэн хийсэн юм. Ингэхэд нэгэн хүндрэлтэй асуудал гарсан нь Халхын Дөрвөн аймгийн өдгөө бидний гар дээр уламжилж ирсэн эх сурвалжууд тооны хувьд харилцан адилгүй байдаг оршино. Дээрх шалтгаанаас үүдэлтэй Түшээт хан, Сэцэн хан аймгийн эх сурвалжууд сайн хадгалагдсан учир энэ чиглэлийн судалгаанд түлхүү ордог, харин Засагт хан, Сайн ноён хан аймгийн холбогдолтой зарга бичиг нь цагийн эрхээр үрэгдэж тун цөөн тоотой үлдэж бидний үед хүрч иржээ. Контент анализын судалгаа нь судалгааны хэрэглэгдэхүүн болгож ямар төрлийн баримт бичгийг сонгож авч байгаагаас үр дүн нь шууд хамаарч байдаг тул үүнийг харгалзан үзэх хэрэгтэй болно. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдах заргын бичгүүд тухайн үеийн түүхэн нөхцөл байдлыг харуулж чадахуйц олон төрлийн шинж чанарыг хадгалсан байх нь чухал юм. Гэтэл Улсын Төв Архивт хадгалагдаж байгаа заргын бичгийн нийт тоо нь тодорхойгүй, ангилах, сэдэвчлэх зэрэг боловсруулах ажил төдийлөн хийгдээгүй байгаа нь судалгааны түүврийн зохистой хэмжээ, төрөл, шинж чанар зэргийг тогтооход бэрхшээл учруулж байна.

*Хоёрдугаарт*, дээр өгүүлсэн заргын бичгийн судалгааг түүхч, судлаачид хийхдээ цаг үеийнхээ нөхцөл байдал, үзэл суртал, ангийн тэмцэлтэй холбоотойг харуулах<sup>19</sup> баримтыг түүвэрлэн авсан буюу формацын онол арга зүйн дагуу хийгджээ. Тиймээс Манжийн үеийн Монголын нийгмийн доод давхаргын төлөөлөл болох хамжлага, шавь, сум жир ардууд, бага тайж нарыг 1990-ээд оноос өмнөх түүх бичлэгт *ард* хэмээх ерөнхий ойлголтод багтаан хамааруулж тэдний өргөсөн заргын бичгүүдийг *ардын заргын бичиг* гэж тодорхойлон ойлгож байжээ. Чухамдаа ингэж нэрлэх болсон шалтгааныг ч дээрхтэй холбон үзэж болох учраас *ардын зарга* гэсэн нэр томъёог эргэн харах шаардлага зүй ёсоор үүснэ. Гэтэл Халх Дөрвөн аймгийн Чуулганы дарга, жанжны жасаа, дээрх аймгуудын харьяа хошуу тамгын газруудын данс бичгийг архиваас нягтлан судлахад заргын бичиг нь Манжийн үеийн Монголын нийгмийн бүх давхаргыг хамарч байсан нь тодорхой байна. Хэрвээ үүнийг харгалзвал *ардын заргын бичиг* гэсэн нэр томъёог *монгол зарга бичиг*, эс бөгөөс *зарга бичиг* хэмээн *ардын* гэсэн тодотголгүй нэрлэх саналыг дэвшүүлж байна. Тэгэхлээр цаашдын судалгаанд заргын олон төрлийн шинж, чанарыг харгалзан үзэхээс гадна, дан нэг төрлийн заргын бичгийг олноор оруулах нь судалгааны үр дүнд шууд нөлөөлнө гэдгийг тооцмоор байна. Жишээлбэл дан ангийн тэмцэлтэй холбоотой заргыг, эсхүл зөвхөн газрын харилцааны асуудлыг хөндсөн заргын бичгийг судалбал

<sup>16</sup> Ч. Тамир., "Түүхийн социологи: Өнөөгийн байдал, цаашдын хандлага", Социологи сэтгүүл, МУИС, Улаанбаатар, 2(2002), 60-р тал.

<sup>17</sup> *Ардын заргын бичиг* (XVIII-XX зууны эхэн), эмхэтгэсэн Ш. Нацагдорж, Ц. Насанбалжир, хянан тохиолдуулсан Д. Гонгор, Улаанбаатар, Шинжлэх Ухааны Академийн Хэвлэх Үйлдвэр, 1966, 244 тал.

<sup>18</sup> Ч.Тамир., "Ардын зарга нь улс төрийн оролцооны нэгэн хэлбэр мөн", Түүх. Эрдэм шинжилгээний бичиг. МУИС. 2003.

<sup>19</sup> Гэвч эдгээр заргууд шууд ангийн тэмцлийг харуулах баримт болж чаддаггүй гэсэн дүгнэлт өмнөх судалгаагаар гарсан. Эл таамаглалыг бид үргэлжлүүлэн шалгаж байна. Ч.Тамир., "Ардын зарга нь улс төрийн оролцооны нэгэн хэлбэр мөн", Түүх. Эрдэм шинжилгээний бичиг. МУИС. 2003. Дүгнэлт хэсгээс үзнэ үү.

тэр л чиглэлийн тодорхой хүрээнд хязгаарлагдсан дүгнэлт гарна гэдгийг урьдчилаад хэлчихэж болно. Тэгэхлээр түүвэр олонлогийн (түүвэрлэн авсан зарга) хүрээнд хийгдсэн дүгнэлтийг эх олонлогт (нийт заргын бичиг, гэхдээ үүнд зөвхөн одоо хадгалагдан үлдсэн заргын бичгийг хамруулах нь онолын хувьд бас л учир дутагдалтай юм.) хамруулан үзэж болохгүй нь тодорхой юм<sup>20</sup>.

*Гуравдугаарт*, манай өнгөрсөн түүх бичлэгт цаг үеийн байдлаас шалтгаалан аливаа түүхэн үйл явцад нийгмийн хүчин зүйлийн гүйцэтгэсэн үүргийг хэтрүүлэн үнэлэх хандлага түгээмэл оршоор байжээ. Харин монголчуудын нүүдлийн амьдралын хэв маяг нь байгаль орчинтой нэн уялдаа шүтэлцээтэйгээр оршин хөгжиж ирсэн бөгөөд энэ ч үүднээс тухайн түүхэн цаг үеийн жир иргэдийн амьдрал, ахуй байдалд байгаль, цаг уурын нөхцөл (ган, зуд, өвчин тахал гэх мэт) байдал ихээхэн нөлөө үзүүлж байсныг тооцохгүй өнгөрөх аргагүй юм. Иймээс монголчуудын заргын тэмцлийн үйл явцад байгаль, нийгмийн хүчин зүйлсийн үзүүлсэн харилцан нөлөөг цаашид тодруулан судлахад анхаарах хэрэгтэй байна.

*Дөрөвдүгээрт*, өмнө нь хэвлэгдсэн заргын бичиг ихэнхдээ бүрэн эхээрээ бус хэсэгчилсэн байдлаар авсан байдаг, мөн удаан хугацаанд үргэлжилсэн зарга гарсан тохиолдолд зөвхөн нэг л удаагийн заргын бичгийг сонгон авсан зэрэг учир дутагдал байв. Үүнийг монголчуудын уламжлалт албан бичгийн хөтлөлт ихээхэн нуршуу үгтэй байдаг, хичээнгүй сайд Д. Цэрэндоржийн тэмдэглэсэнчлэн "Манай хуучин албан бичлэгийн дотор сул үг нь дарчихаад гол санаа нь бүрхэгдэх удаа буй. Энэ байдлыг өөрчлөх хэрэгтэй"<sup>21</sup> гэсэнтэй, мөн нэг асуудлаар бичигдсэн хэд хэдэн зарга нь өөр хоорондоо ялгаатай боловч давтагдсан санаа нь давамгайлсан байдаг зэргийг манай судлаачид харгалзан үзсэн нь лавтай. Гэвч ингэж хэсэгчлэхэд зарим нэг баримт орхигдон үлдэх аюул бий. Тиймээс бид энэ судалгааг үргэлжлүүлэн явуулахдаа зөвхөн нэг удаагийн заргын бичигт хөтлөгдөөгүй, харин заргын эхэлсэн ба үргэлжилсэн, дууссан бүхэл бүтэн үйл явцыг багтаасан баримт бичгийн шинжилгээний хэрэглэгдэхүүнийг урьдчилан бэлтгэхийг хичээсэн юм. Тухайлахуйаа удаан хугацаанд үргэлжилсэн, нэг бус удаа давж заалдсан заргыг судлахдаа бүхий л заргуудыг уншиж үзээд судалгааны хэрэглэгдэхүүнийг бөглөсөн болно. Чингэснээр өмнө өгүүлсэн алдааг давтахаас зайлсхийхийг хичээв.

*Тавдугаарт*, өмнөх судалгаа нь тооны хувьд харьцангуй цөөн байсныг тэмдэглэн хэлэх хэрэгтэй. Баримт бичгийн аргын нэгэн төрөл контент анализын арга нь тоон судалгааны аргад хамаарах ба үр дүн нь хувиар гардаг. Социологийн тоон судалгааг явуулахад түүврийн хэмжээ чухал, ялангуяа тухайн үзэгдэл үйл явцыг дотор нь ангилж, хүчин зүйлээр нь бүлэглэх, өөр хооронд нь харьцуул ах, цаашилбал логик хам аарал, корреляци, дисперси зэрэг математик, статистик төрөл бүрийн боловсруулалтыг гүнзгийрүүлсэн төвшинд хийхэд түүврийн хэмжээ хангалттай байх шаардлагатай. Жишээлбэл заргыг наад зах нь зарга хийсэн оноор, зарга хийсэн газраар, заргад оролцсон нийгмийн бүлэг бүрээр нь ангилан судлах нь үзэгдэл юмсын учир шалтгаан, хүчин зүйлсийн өөр хоорондын уялдаа холбоо, хууль зүй тогтлыг нээн гаргахад ихээхэн ач холбогдолтой байх нь эргэлзээгүй юм.

Бидний энэ судалгаа нь заргын бичгийг түүхийн социологийн арга зүйгээр судлан үзэх эхний оролдлого тул судалгааны онол арга зүй, аргачлал, техникийн хувьд ч гэсэн доголдолтой, ойлголтыг буруу хэрэглэсэн, бүлэглэсэн, хооронд нь хольсон, заримыг нь орхисон зэрэг алдаа гарсан байхыг үгүйсгэхгүй. Хэдий ийм ч ахмад судлаачид энэ судалгааг цааш үргэлжлүүлэн хийх сэтгэлийн дэмийг өгсөн ба урам зоригийг сэргээсэн авай. Тиймээс энэ судалгааг үргэлжүүлэн явуулж байгаа\* бөгөөд үр дүнг нь уншигч абугай таньд толилуулахдаа туйлын баяртай байх болно.

Эцэст хураангуйлан өгүүлбэл заргын бичиг бол утга агуулга, шинж чанарын хувьд тухайн үеийнхээ нийгмийн бүх асуудлыг хамарч чаддагаараа онцлог, бусад түүхэн эх сурвалжуудтай харьцуулахад ялгаатай, олон талын онцлог, ач холбогдолтой түүхэн баримт

<sup>20</sup> "С. Төмөр-Очир., *Түүврийн арга*, Социологийн судалгааны үндсэн аргууд, хянан тохиолдуулсан В. Отгоннасан, Улаанбаатар, 1993, 49-54-р тал.

<sup>21</sup> Д. Ядамсүрэн., *Ардын төрийн ахмад зүтгэлтэн Балингийн Цэрэндорж*, хянан тохиолдуулсан Д. Гонгор, Шинжлэх Ухааны Академийн Хэвлэл, 1967 он, 24 тал.

\* Цаашид эл чиглэлээр цуврал байдлаар нэлээд хэдэн өгүүлэл гарахаар төлөвлөж байгаа болно.

бичиг учир заргын бичгийг төрөл бүрийн шинжлэх ухааны тусгайлсан аспектаар (түүхээс гадна социологи, улс төр судлал, эдийн засаг, хууль, хэл шинжлэл, төрийн удирдлага гэх мэт) судлахаас гадна салбар хоорондын хавсарга арга зүйгээр судлах нь үр өгөөжөө өгнө гэж бид үзэж байна.

#### ABSTRACT

This work is the research about Mongolian petition related with the XIX-XX century. Petition is not only considerable but related document which doesn't have from other research sources. It's different because the petition shows Mongolian ordinary civil life, honesty, intellegence, and social problems without any filter, and if gives us the opportunaty to research and study tradition, culture of formal letter, the abuse of authority and law and social problems and its conflict. It raises some issues about methodology and method how to study petition with sociological new aspects of history further.